

ЗОХИОЛЫН ДҮРСЛЭХ БА УРАН ЯРУУ ХЭРЭГЛҮҮР

Хэлний уран яруу хэрэглүүр зохиолыг уран яруу соносголтой, яруу сонирхолтой, амттай болгох зорилгоор зохиолч хэлний янз бүрийн дүрслэх аргуудыг ашиглана. Үүнийг зохиолын хэлний уран яруу хэрэглүүр гэнэ. Хэлний уран яруу хэрэглүүрт утга шилжүүлэх ёс, хэтрүүлэл адилтгал, зүйрлэл, төлөөлөл, чимэг үг, багасгал, билгэдэл, егөөдөл зэрэг маш олон дүрслэлийн аргууд багтдаг. Зохиолд хэлний уран яруу хэрэглүүрийг сонсголонтой, аялгуутай, амттай, тансаг байдал бий болгоход ашигладаг. Мөн хэлний уран яруу хэрэглүүрийг хэрхэн ашигласнаар нь зохиолчийн билиг авьяасын хэр хэмжээг тодорхойлж болдог.

Уран дүрслэлийн хэрэглүүрийг:

- Дүрслэх
- Яруу гэж хоёр ангилна.

Дүрслэх хэрэглүүр

-Чимэг үг	- Ёгтлол
-Зүйрлэл	- Амьдчилал
-Адилтгал	- Хүншүүлэл
-Хэтрүүлэл	- Юмшүүлэл
- Ихэсгэл	- Төлөөлөл
-Багасгал	- Егөөдөл

Яруу хэрэглүүр

- Яруу асуулт	-Сөөлжүүлэл
- Яруу хандал	-Тодорхойлол
- Яруу анхааруулга	-Харшуулал
- Яруу дуулал	-Сөргүүлэл
- Давталт	-Тоочилт
- Эхэн	-Өрнүүлэл
- Сүүл	-Утга шилжүүлэл
- Ахиулал	-Тойруулал
-Зэрэгцүүлэл	- Зориуд дараалал өөрчлөх

Чимэг үг

Уран зохиолд уран яруу хэрэглүүрийн үүрэг гүйцэтгэдэг. Чимэг үг бол юм, үзэгдэл, үйл явдлын гол шинжийг нээн гаргахад тусладаг уран сайхны тодорхойлолт юм.

Жишээ нь:

Хөх манхан тэнгэр -ийг эзэгнэнхэн төрлөө би!

Хөмсгөн сар -ны аялах алсын алс тойрогт

Холын хоёр од -ны тохиох бяцхан чөлөөнд

Хоёр нүд -ний үзүүрт цэнхэртэх төдий тэртээд

Хөх манхан тэнгэр -ийг эзэгнэнхэн төрлөө би!

Зүйрлэл

Үгийн утга шилшүүлэх ёсны нэг хэлбэр, дүрслэлийн уран хэрэглүүр юм. Нийтлэг төсөөтэй шинж бүхий хоёр юм, үзэгдэл, ойлголтыг хооронд нь жишиж нэгний нь уран сайхны онцлогийг ялгаруулан тодруулдаг дүрслэлийн аргыг хэлнэ.

Жишээ нь: Ц.Дамдинсүрэн “2 настай Ро” шүлэг

Аавдаа алт болсон

Ээждээ эрдэнэ болсон

Энхрий булбарай бие нь

Эсэн мэндээр хүмүүжиг

Адилтгал

Дүрслэлийн нэгэн зүйл уран яруу хэрэглүүр болно. Төрлийн олон зүйлийг нөгөө зүйлд юм уу зүйлийг төрөлд эсвэл өөр зүйлийг адил төрлөөр нь ижилсүүлэн дүрслэх аргыг адилтгал гэнэ.

Жишээ нь: Б. Явуухулан “Ой мод” шүлэг

Мод заримдаа хүн шиг

Алаг эрээн амьдралын

Аливаа тавиланг

Амсаж байна

Хэтрүүлэл

Хэлний уран уран яруу хэрэглүүр. Дүрслэлийн нэгэн зүйл арга юм. Яруу сайхны сэтгэгдэл төрүүлэхийн үүднээс юмс, үзэгдэл, үйл явдлын аль нэг шинж байдлыг уран сайхны аргаар хэтрүүлэн давуулж дүрслэхийг хэлнэ.

Хэтрүүллийг дотор нь дүрслэн үзүүлж буй байдлаар нь ихэсгэл, багасгал гэж ангилна.

Ихэсгэл

Уран сайхны дүр, дүрслэгдэхүүний яруу сайхныг нээх зорилгоор юмс, үзэгдлийн шинж төрх, байр бадлыг байгаагаас нь ихэсгэн томруулж, хүч нэмэгдүүлэн сүрлэг болгож дүрслэх арга болно.

Жишээ нь:

Д.Нацагдорж “Цагаан сар ба хар нулимс” өгүүллэг

“... Тэдний инээх, идэх уух нь гэр хагармаар”

Багасгал

Дүрслэлийн уран яруу хэрэглүүр юм. Яруу сайхны сэтгэдэл төрүүлэх үүднээс юм, үзэгдэл, үйл явдлын аль нэг шинж байдал төрхийг байгаа байдлаас нь уран сайхны аргаар багасган жижигрүүлж дүрслэх аргыг багасгал гэнэ.

Жишээ нь: “Монголын нууц товчоо” –оос

Шүдний махаар хоол хийж

Шүлсний хөөсөөр унд хийж

Ёгтлол

Утга шилжүүлэн далдлах арга. Нэг зүйлийн уран хэрэглүүр. Олон тал нь төсөө бүхий юм, үзэгдлийг өөр үгээр орлуулан хэлж бичээд үндсэн санаагаа далдуур гаргасныг ёгтлол гэнэ.

Жишээ нь:

Эх нь хээр алаг бол

Унага нь шийр алаг

Амьдчилал

Амьдчилалыг хүншүүлэл, юмшүүлэл зэргээр ангилан нэрлэх нь бий. Хүн ба юмсад байдаг шинжүүдийг өөр бодис юмсад шилжүүлэн амьтай мэтээр бичих аргыг амьдчилал гэнэ.

Хүншүүлэл

Амьдчилах аргын нэг хэлбэр бөгөөд амьтай ба амьгүй юмс хүн мэт өгүүлэн уг үзэгдэл явдлын нуугдмал талыг нээх арга болно.

Жишээ нь:

Хуульч Сандаг “Шаазангийн үг”

Хөндий газар тавь

Хүүхдэд бүү үзүүл

Намайг дуугарвал

Насгүй гэж мэдээрэй

Юмшүүлэл

Хүн амьтанд байдаг гол гол шинжүүдийг өөр амьгүй бодис юмст шилжүүлэн дүрслэн яруу болгосныг хэлнэ.

Жишээ нь: М. Амгалан “Тарни” өгүүллэг

... Манай энэ гэж ёстой нэг бул хар чулуу, дүлий хар годил...

Төлөөлөл

Энэ нь нэг юмыг нөгөөгөөр шилжүүлэн дүрсэлдэг арга учраас бэлгэдэлтэй гүнзгий холбоотой. Уран дүрслэлийн уран маяг юм.

Хоорондоо ямар ч төсөөгүй зүйлийг гадаад дотоод аль нэг шалтгаант холбоогоор нь /харилцан шүтэлцсэн/ дамжуулан хамааруулж нэгийг нөгөөгөөр орлуулж дүрслэх уран яруу хэрэглүүрийг төлөөлөл гэнэ.

Жишээ нь:

А.С Пушкины “”Евгений Онегин” зохиолд “”Апулейг унших дуртай атлаа Цицероныг сөхөж хардаггүй гэж гардаг Энэ нь Апулейг “Алтан илжиг” гэдэг зохиолыг шимтэн уншдаг, харин Цицероны зохиолыг уншдаггүй гэсэн утгатай

Д.Пүрэвдорж “Хар цас” найраглал

Таван сарын есний нарыг
 Улаан арми авч ирээгүй бол
 Тас хар энэ цас
 Уужим орчлонг дарах байлаа.

Егөөдөл

Уран дүрслэлийн утга шилжүүлэн бичих хэрэглүүр юм. Юмс үзэгдлийн гол мөн чанар аль эсвэл нэг шинжийг шууд утгаар бус харин бүр эсрэг утгаар сөргүүлэн гаргаж тэдгээрийн хооронд агуулагдаж байгаа зөрчлийн эрчмийг ихэсгэх уран сайхны шоглолын аргыг егөөдөл гэнэ.

Жишээ нь:

Д.Нацагдорж “Цагаан сар ба хар нулимс” өгүүллэг
 ... Цэрмаа гал тогоотой хуримлана.
 Ч. Лодойдамба “Тунгалаг Тамир” роман
 ... Манай Ням гуай ч шарсан мах андахгүй шар зурхайч даа.

Яруу асуулт

Дүрслэлийг яруу сайхан болгох, сэтгэлийн хөдөлгөөний эрчмийг идэвхжүүлэн төгс төгөлдөр илэрхийлэн гаргахын тулд уншигчаас ямар нэгэн хариулт авах зорилгоор орсон яруу хэрэглүүрийг хэлнэ.

Жишээ нь:

Дээгүүр чинь тэгнэх гүүрний 2 ногоон арслан л
 Дэргэдүүрээ өнгөрөх болгоноос усаа харамлан архирах юм
 Чулуун арслангаас өөр өмөөрөх эзэнгүй юм бол
 Чухамдаа тэгээд энэ чинь хэний гол юм бэ?

Яруу хандал

Яруу найрагчаас бодит байдлын юмс үзэгдэлд яруу сайхны учир зорилгын үүднээс хандсан уран дүрслэл юм.

Жишээ нь:

Г.Мэнд-Ооёо “Үгийн билиг” шүлэг
 Авирлагч хэн нэгний
 Алдрын тэнгэрт нисгэсэн
 Асарлагч нэгнээ
 Газрын мухарт үүртгэсэн
 Бурангуй буртаг тоосыг
 Тунгаан шүү хэл минь
 Харанхуй дунд гэрэлтэхээр
 Тунгалаг бай хэл минь

Яруу анхааруулга

Уран зохиолд баатрын бодол санааны ертөнцийг тодруулан дүрслэх, сэтгэл хөдлөлийн байдлыг нээх зорилгоор зориуд анхаарал татан төвлөрүүлэхээр хэрэглэсэн өгүүлбэр зүйн уран маягийг яруу анхааруулга гэнэ.

Жишээ нь:

Ш. Сүрэнжав “Гар” найраглал
Гар гэдэг олдсноо шүүрч аваад
Аманд хийдэг
Эрхтэн биш
Гар гэдэг
Онгоцны дээрээс
Бөмбөгний товч мултлах
Эрхий биш

Яруу дуулал

Ямар нэгэн зүйлийг дүрслэхдээ сэтгэл хөдлөлийн хэлбэрээр баталсан юм уу үгйгсэсэн чанартай найруулгын ур маяг элбэг тохиолддог үүнийг яруу дуулал гэнэ.

Жишээ нь:

Хувь заяа нь эгзэгтэй
Хурдны морь хөөрхий
Хотлыг цэнгүүлээд өнгөрдөг
Ховорхон морь хөөрхий

Ахиулал

Уран зохиолын уран маяг юм. Үг хэлээр хүний сэтгэлийн хөдөлгөөн үйл явдлын өрнөлийг эрчимжүүлэн илэрхийлэх нэг зүйл давталын хэлбэрийг ахиулал гэнэ.

Жишээ нь:

Монголын үзэсгэлэнт саран гуа намайг төрүүлсэн ээж
Яруу сайхан эгшгээрээ бөн бөн бүүвэйлсэн
Зөөлөн цагаан гараараа хөдөлгөн өсгөсөн ээж
Зүйтэй уран үгсээрээ сурган хүмүүжүүлсэн ээж

Зэрэгцүүлэл

Утга, чанар, шинж байдлаараа төстэй 2 өөр үзэгдлийг ерөнхийлөн адилтгаж, өгүүлбэрийн төстэй байгууламжид тэнцүүлэн тэгш эрхтэйгээр зэрэгцүүлэн дүрсэлж нэгэн санааг тодруулан гаргах найруулгын ур маяг юм.

Жишээ нь: Д.Пүрэвдорж “Сумын наадам” шүлэг
Суусрын гүйдэл салх шанхаар наадан сэвэлжнээс
Суурь хөлгөн асрын шашир цацаг дэрвээ юү

Сумын наадмын дэвжээг өндөржин тойрох морьтноос
Суран жолоо атгасан өнгийн цэцэг ургаа юу

Удаашруулал

Уянга туульсын зохиолд үйл явдлын өрнөлийг зориуд удаашруулах зорилгоор хийсэн зохиомжийн нэг нэг зүйлийг удаашруулал гэнэ.

Жишээ нь: Ж.Дашдондог “Аранзал зээрд” шүлэг

Аранзал зээрд морьныхоо

Амыг татан цогиуллаа

Цогиулснаа хатирууллаа

Хатируулснаа ерүүлээ

Ергүүлснээ шогшууллаа

Шогшуулснаа алхууллаа

Анхааруулал

Уран зохиолын уран маяг. Нэгэн зүйл дүрслэх хэрэглүүр болно. Ямар нэг зүйлийг дүрслэхдээ танин мэдэхүйн үүднээс батлан анхааруулсан чанартай уран маяг, яруу найрагт элбэг тохиолддог. Үүнийг утга зохиолын онолд анхааруулал гэнэ.

Жишээ нь: Д. Равжаа

Нанчид нанчид гэвч

Нарийн хар архи

Нарийвчлан шинжвэл

Найман тамын нэг

Там там гэвч

Там хаанаас байхав

Тамтагтгүй явбал

Там чинь тэр буй заа

Хураангуйлал

Шүлэг зохиолыг уран яруу тансаг, тод оновчтой болгох, баатрын сэтгэлийг хөдөлгөөнийг гаргах, эрчимжүүлэх, бууруулахын тулд өгүүлбэрийн аль нэг гишүүнийг зориудаар хасаж бичих уран маяг юм. Үүнийг товчлол, орхилт гэж бас нэрлэнэ.

Жишээ нь:

Би явж байна

Бээжин сууж байна.

Сөөлжүүлэл

Нэг язгууртай боловч хэлний зүйн хэлбэрийн хувьд ондоо үгсийг хослуулан ашиглах нэг зүйл уран дүрслэлийн аргыг хэлнэ.

Жишээ нь: Д.Пүрэвдорж “Сумын наадам” шүлэг

Больё гээд болдоггүй
 Богинохон заяа хөөрхий
 Больё гээд болохгүй
 Борхон зүрх хөөрхий

Тодорхойлол

Ямар нэг зүйлийг дүрслэн үзүүлэхдээ хувийн амьдралын туршлагаар батлагдсан голч үнэний тухай хийсвэрлэн батлах чанартай уран маягыг хэлнэ.

Жишээ нь: МНТ –оос
 Ширмэн төмөр магнайтай
 Шивээ хурц хэлтэй
 Ган төмөр зүрхтэй
 Галзуу дөрвөн нохой

Харшуулал

Эсрэг тэсрэг ухагдахуун, санаа, шинж, төрхийг илэрхийлэх зорилгоор үг хэллэг, дүрслэлийг зэрэгцүүлэн тавьж харшуулан, ухагдахуун тус бүрийг товойлгон тодруулах буюу хамтатган үл зохилдохыг илэрхийлэх найруулгын ур маягыг хэлнэ.

Жишээ нь:

Ш. Данзанваанжил “Түнгийн зуугийн гэгээний алтан сургаал”
 Галын өнгө улаан ч
 Утаа нь харавтар
 Гарах сургаал тустай ч
 Үгс нь дайвар

Утга шилжүүлэл

Уран дүрийг бүтээхдээ үг өгүүлбэр, хэллэгийг шууд бус шилжсэн утгаар нь ашигласныг хэлнэ.

Жишээ нь:

Бурхан шиг ахад буга шиг дүү заяасан санагдаад байна.

Зориуд дараалал өөрчлөх

шүлэгт тааруулах, үг утгыг онцгойлон ялгаруулах ярианы өнгө аясыг тодорхой болгох зорилгоор, санаатайгаар эсвэл өгүүлбэрийн байгуулалтыг эвдэн дүрслэх ур маягыг хэлнэ.

А.С. Пушкин “Евгений Онегин”
 Хэн Онегиноос салах над шиг
 Хэрэг төвөггүй салж байна
 Тэр бол чухам азтай хүн гэж
 Тэмдэглэе би, эцсийн бүлэг